



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2009 оны нэгдүгээр сарын 20

№3 (576)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |  |    |
|-----|--|----|
| 26. | "Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц"-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай | 38 |
| 27. | Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 38 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |   |           |    |
|-----|---|-----------|----|
| 28. | Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай  | Дугаар 01 | 39 |
| 29. | Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох тухай   | Дугаар 02 | 39 |
| 30. | Улсын Их Хурлын тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан Тамгын газрын дүрмийн заалт хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 03 | 39 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |     |  |            |    |
|-----|--|------------|----|
| 31. | Цэрэнпилийн Балхаажавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 384 | 39 |
| 32. | Жанцандоржийн Амгалад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай  | Дугаар 385 | 40 |
| 33. | Юлтын Жаргалд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай                        | Дугаар 387 | 40 |
| 34. | Энхбаярын Равданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай                          | Дугаар 388 | 40 |
| 35. | Зундуйн Жанжаадоржид Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан цол хүртээх тухай      | Дугаар 389 | 40 |
| 36. | Цэдэндэмбын Балдандоржид Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан цол хүртээх тухай  | Дугаар 390 | 41 |
| 37. | Нямын Мишигдоржид Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай                  | Дугаар 391 | 41 |
| 38. | Жамбалын Халзанбандид Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай              | Дугаар 392 | 41 |
| 39. | Дондогийн Гарамжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай       | Дугаар 393 | 41 |
| 40. | Бадамын Балганд Монгол Улсын ХАА-н гавьяат механикжуулагч цол хүртээх тухай            | Дугаар 394 | 42 |
| 41. | Лувсандашийн Доржид Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай                    | Дугаар 395 | 42 |
| 42. | Уранчимэгийн Мөнх-Эрдэнэд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай              | Дугаар 396 | 42 |
| 43. | Довдонгийн Данзанд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай             | Дугаар 397 | 42 |

## Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

44.	Сайдын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийн тухай	Дугаар 66	43
45.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 67	43
46.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай	Дугаар 68	44
47.	Дэд сайдын орон тоог тогтоох тухай	Дугаар 73	45

## Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

48.	Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 47	45
-----	---	-----------	----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### "ГАДААДЫН АЛБАН ЁСНЫ БАРИМТ БИЧГИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ШААРДЛАГЫГ ХАЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ"-Д МОНГОЛ УЛС НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн есдүгээр бага хурлаас 1961 оны 10 дугаар сарын 5-ны өдөр баталсан "Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц"-д Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоно.

**3 дугаар зүйл.** Баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгох журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**2 дугаар зүйл.** Конвенцийн гишүүн улсуудад хэрэглэгдэх баримт бичгийг гадаад харилцааны

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн "ашиглахтай" гэснийг "ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдлэлбэрийн орчныг хамгаалахтай" гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "56 дугаар зүйлд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан" гэснийг "53-56 дугаар зүйлд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг хүлээлгэн өгсөн" гэж тус тус өөрчилсүгэй.

хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн "эрэл", гэснийг болон 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон, түүнчлэн" гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Алагийн Батсүхийг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сүрэнгийн Пүрэвдоржийг томилсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Монголбанкны Ерөнхийлөгчөөр Лханаа-

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### Улсын Их Хурлын тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан Тамгын газрын дүрмийн заалт хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

дугаар сарын 22-ны өдрийн 62 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Тамгын газрын дүрмийн 5.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

1. Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан "Бодлогын шинжилгээний төв байгуулах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар тогтоол, "Тамгын газрын дүрэм батлах тухай" 2006 оны 6

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

### Цэрэнпилийн Балхаажавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухаан, боловсролын салбарт он даан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх, соён эгээрүүлэх болон удирдан зохион байгуулах ажлынхаа үр дүнгээр монгол орны хөгжил дэвшил, нийгмийн амьдралын утга учрыг өөрийн орны иргэдэд болон гадаад орны иргэдэд шинжлэх

ухаанчаар танин мэдүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж төр, нийгмийн ахмад зүтгэлтэн Цэрэнпилийн Балхаажавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

**Жанцандоржийн Амгаланд Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Шинжлэх ухааны салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм шинжилгээ-судалгаа, үйлдвэрлэлийн чухал ач холбогдолтой бүтээлүүд туурвиж, механикийн аргаар экологийн цэвэр хаягдалгүй фосфорын бордоог үйлдвэрлэх шинэ технологи боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлж, Монгол Улсад химийн шинжлэх ухааныг бэхжүүлэн хөгжүүлэхэд оруулсан

хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, академич Жанцандоржийн Амгаланд Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 387

Улаанбаатар хот

**Юлтын Жаргалд Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээх тухай**

Төрийн захиргаа, батлан хамгаалах, барилгын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, эзвэсэгт хүчний анги, салбаруудын ар талын хангалтыг сайжруулах, барилгын цэргийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, цэргийн албан хаагчдыг орон сууцаар хангах, цэргийн хотхон, аймаг, нийслэлийн олон арван барилга байгууламжийг барих ажлыг чадварлаг удирдан

зохион байгуулж, барилгын салбар болон нийслэл Улаанбаатар хотын хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлж "Майн-Инфо" ХХК-ийн зөвлөх инженер, хошууч генерал Юлтын Жаргалд Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

**Энхбаярын Равданд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Дээд боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллан сургалт-эрдэм шинжилгээ, толь бичиг, орчуулгын олон арван шилдэг бүтээл туурвиж, орос-слав, орос-англи судлалын үндэсний боловсон хүчин, багш нарыг сургаж бэлтгэх, Монголын орос хэл-уран зохиолын багш нарын холбоог үүсгэн бэхжүүлэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийн багш, доктор, профессор Энхбаярын Равданд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

**Зундуйн Жанжаадоржид Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээх тухай**

Төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, ус ашиглалт, хамгаалалтын улсын албыг үүсгэн бэхжүүлэх, байгаль орчны салбар, түүний дотор усны салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, гадаад харилцааг

хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Усны үндэсний хөтөлбөрийг дэмжих төвийн захирал Зундуйн Жанжаадоржид Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

### Цэдэндамбын Балдандоржид Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээх тухай

Төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд усалгаатай тариалан эрхлэх, усны нөөцийг зохистойгоор ашиглах, хамгаалах чиглэлээр эрдэм шинжилгээ-судалгааны томоохон цуварал бүтээлүүд туурвиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, усны аж ахуйн салбарын инженер-

техникийн ажилтнууд, мэргэжилтэй ажилчдыг сургаж бэлтгэх, дадлагажуулах, усны салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Усны институтын зөвлөх Цэдэндамбын Балдандоржид Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 391

Улаанбаатар хот

### Нямын Мишигдоржид Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай

Төрийн захиргааны төв болон эдийн засаг, санхүү, статистик, гадаад харилцааны салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, гадаад орнуудын зээл тусламжийг нэмэгдүүлэн оновчтой ашиглах, хамтарсан үйлдвэр байгуулах зэрэг олон чухал санал санаачилга гарган хэрэгжүүлж, гадаад харилцааны олон талт хамтын ажиллагааг өргөтгөх, үр ашгийг дээшлүүлэх, тус

салбарын үйл ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж "Капитал" банкны зөвлөх Нямын Мишигдоржид Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 392

Улаанбаатар хот

### Жамбалын Халзанбандид Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай

Түлш, эрчим хүч, уул уурхайн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж тус салбарын санхүү, эдийн засгийн албыг бэхжүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн эдийн засгийн нөхцөлд жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалах, татварын хуулиудыг хэрэгжүүлэхэд

оруулсан хувь нэмрийг үнэлж Монголын татвар төлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал Жамбалын Халзанбандид Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 393

Улаанбаатар хот

### Дондогийн Гарамжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Геологи, эрдэс баялгийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, геологийн шинжлэх ухаан-судалгааны чиглэлээр томоохон бүтээлүүд туурвиж, монгол орны эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх Эрдэнэтийн овоо, Оюу толгой зэрэг зэс-алтны ордуудыг нээж ашиглалтад бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж "Айвенхоу майнз

Монголия-Инк" ХХК-ийн зөвлөх геологич Дондогийн Гарамжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

### Бадамын Балганд Монгол Улсын ХАА-н гавъяат механикжуулагч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан Монгол Улсад өндөр үр ашигтай чацаргана ургуулж шинэ сорт бий болгох, чацарганы жимс хураах, боловсруулах шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, жимс жимсгэний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг

нь үнэлж "Хаан чацаргана" ХХК-ийн захирал Бадамын Балганд Монгол Улсын ХАА-н гавъяат механикжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 395

Улаанбаатар хот

### Лувсандашийн Доржид Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, цанын спортын төрлөөр олимп, тив, дэлхий, олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцон алт, мөнгө, хүрэл медаль хүртэж, цанын спортыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын цанын холбооны ерөнхий

нарийн бичгийн дарга, олон улсын хэмжээний мастер Лувсандашийн Доржид Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 396

Улаанбаатар хот

### Уранчимэгийн Мөнх-Эрдэнэд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Сонирхогчдын боксын спортын төрлөөр олимп, тив, дэлхий, олон улс болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцон "Бээжин-2008" зуны олимпын их наадмын шагналт 5 дугаар байр эзэлж, Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээний алт, Дэлхийн цомын

аваргын мөнгөн медаль хүртсэн амжилтыг нь үнэлж Боксын үндэсний шигшээ багийн тамирчин Уранчимэгийн Мөнх-Эрдэнэд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

### Довдонгийн Данзанд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын ард түмний соёлын үнэт өв болсон үндэсний бөхийн уламжлал, ёс жудаг, түүхийг судлан сурталчилж дэлгэрүүлэх, бөхийн залгамж үеийг сургаж бэлтгэх, Монгол үндэсний бөхийг шинэчлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын үндэсний бөхийн холбооны дэд

тэргүүн Довдонгийн Данзанд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Сайдын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийн тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын сайдын ажлын хэсэг нь сайдын зөвлөх, сайдын туслах, сайдын хэвлэлийн төлөөлөгч гэсэн 3-аас дээшгүй орон тоотой байхаар тогтоосугай.

2. Монгол Улсын сайдын ажлын хэсгийн зардлыг холбогдох яамдын төсөвт тусган

санхүүжүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С . Б А Я Р**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Б.ДОЛГОР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн удирдлагыг Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга байхаар тогтоосугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

- Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс (хяналт шинжилгээ, үнэлгээний тасагтай);
- Хууль зүйн хэлтэс /архивын тасагтай/;
- Хөгжлийн бодлогын хэлтэс;
- Нийгмийн хөгжлийн хэлтэс;
- Санхүү, төрийн сангийн хэлтэс;
- Цэргийн штаб.

3. Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээндээ хамааруулан Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрыг 41 хүртэл, Архангай, Булган, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 37 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 29 хүртэл орон тоотой байхаар тогтоосугай.

4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосугай:

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар (ус, цаг уур, орчны шинжилгээний албатай);
- Биеийн тамир, спортын газар;
- Боловсрол, соёлын газар;
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;
- Гаалийн алба;
- Мэргэжлийн хяналтын газар;
- Нийгмийн даатгалын хэлтэс;

- Онцгой байдлын хэлтэс;
- Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс;
- Статистикийн хэлтэс;
- Татварын хэлтэс;
- Тээвэр, авто замын газар;
- Улсын бүртгэлийн хэлтэс;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс;
- Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар;
- Хүүхдийн төлөө хэлтэс;
- Цагдаагийн хэлтэс (газар);
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба;
- Шүүхийн шинжилгээний алба;
- Эрүүл мэндийн газар (Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх албатай).

5. Хуульд заасан эрх хэмжээний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах газар, хэлтэс, албадын чиг үүргийг тодорхойлон хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгорт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоол, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 12 дугаар тогтоол, "Төрийн архивын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2007 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 25 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 318 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Б.ДОЛГОР**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

### Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн удирдлагын бүтцийг дараах байдлаар тогтоосуугай:

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;

-Нийслэлийн Засаг даргын орлогч (Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан);

-Нийслэлийн Засаг даргын орлогч (Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан);

-Нийслэлийн Засаг даргын орлогч (Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан);

-Нийслэлийн Засаг даргын орлогч (Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан);

-Улаанбаатар хотын өрөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дараах байдлаар тогтоосуугай:

-Төрийн захиргааны удирдлагын хэлтэс;

-Хотын хөгжлийн бодлогын хэлтэс;

-Санхүү, төрийн сангийн хэлтэс;

-Хууль зүйн хэлтэс;

-Нийгмийн хөгжлийн хэлтэс;

-Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс;

-Үйлдвэрлэлийн хэлтэс;

-Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс;

-Цэргийн штаб;

-Хэвлэл, мэдээллийн алба.

3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дараах байдлаар тогтоосуугай:

-Захиргааны алба;

-Инженерийн байгууламжийн

хэлтэс;

-Хот, нийтийн аж ахуйн хэлтэс;

-Хүнс, худалдаа, үйлчилгээний

хэлтэс;

-Орчны бохирдол, хог хаягдлын

менежментийн хэлтэс.

4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 85 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 40 хүртэл, нийслэлийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тус бүр 50 хүртэл, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр 45 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт тус бүр 35 хүртэл, Багахангай дүүрэгт 25 (нормативаар ажиллах орон тоо орохгүй) хүртэл байхаар тогтоосуугай.

5. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосуугай:

1. Авто замын газар

2. Агаарын чанарын алба

3. Архивын газар

4. Аялал жуулчлалын газар

5. Байгаль хамгаалах газар (Зуслангийн товчоотой)

6. Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар

7. Биеийн тамир, спортын газар

8. Боловсролын газар

9. Газрын алба

10. Мал эмнэлгийн газар

11. Мэдээллийн технологийн газар

12. Мэргэжлийн хяналтын газар

13. Нийгмийн даатгалын газар

14. Нийтийн тээврийн газар

15. Нийслэлийн бүртгэлийн газар

16. Нийтлэг үйлчилгээний газар

17. Онцгой байдлын газар (Нөөцийн албатай)

18. Өмчийн харилцааны газар

19. Соёл, урлагийн газар

20. Статистикийн газар

21. Татварын газар

22. Халамжийн үйлчилгээний газар

23. Хөдөлмөрийн газар

24. Хөдөө аж ахуйн газар

25. Хүүхдийн төлөө газар

26. Цагдаагийн газар

27. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба

28. Шүүхийн шинжилгээний алба

29. Эрүүл мэндийн газар

6. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газруудын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт зөвшөөрсүгэй.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 1 дүээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 196 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсуугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭГЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАГА

Б.ДОЛГОР





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

### Дэд сайдын орон тоог тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

яамдад дэд сайдын орон тоог 1 байхаар тогтоосугай.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайдын орон тоог тус тус 2 байхаар, бусад

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

### Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдэд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу тэтгэвэр, тэтгэмж олгогдох үндэслэлгүй болсон бол олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээгээр, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ багассан, олгогдох хугацаа хойшлогдсон бол зөрүүгээр, хохирсон этгээдээс гарсан нэмэгдэл зардлын хэмжээгээр ажил олгогч Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн холбогдох зохицуулалтаар эд хөрөнгийн хариуцлага хүлээхийг хэлнэ.

#### Нэг. Нийгмийн даатгалын тухай хууль

1.1. Нийгмийн даатгалын тухай /цаашид хууль гэх/ хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т заасан "тодорхой хөдөлмөр эрхлээгүй" гэдэгт ажил, хөдөлмөр огт эрхлээгүйгээс гадна энэ зүйлийн 2-т зааснаас бусад хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгаа хүнийг хамааруулан ойлгоно.

1.3. Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хуулийн 3 дугаар зүйлийн 2-т заасан нийгмийн даатгалын төрөл тус бүрийн бие даасан санг бүрдүүлдэг тул мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан сангийн төрөл тус бүрийг хуулийн 7 дугаар зүйлд заасан "нэг төрлийн сан" гэж үзнэ.

1.2. Хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан "ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй" гэж нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох, нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх ажиллагааг ажил олгогч энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмжээ, хугацаа, 16 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулаагүй, эсхүл эөрчиг явуулсныг хэлнэ.

Хуулийн 7 дугаар зүйлд заасан "нэг төрлийн сангаас тэтгэвэр буюу тэтгэмжийг давхардуулан олгохгүй" гэдгийг даатгуулагчид мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан нэг төрлийн санд хамаарагдах хэд хэдэн тэтгэвэр, тэтгэмжийг авах эрх үүссэн хэдий ч түүнд тэтгэврийн даатгалын сангаас хоёр ба түүнээс дээш тэтгэврийг, тэтгэмжийн даатгалын сангаас цаг хугацааны хувьд нэг дор хоёр ба түүнээс дээш тэтгэмжийг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг нэг зэрэг, хоёр ба түүнээс дээш тэтгэврийг, эсхүл хоёр ба түүнээс дээш тэтгэмжийг цаг хугацааны хувьд нэг дор олгож болохгүй гэж ойлгоно.

Энэ зүйл, хэсэгт заасан "даатгуулагчид учирсан хохирол" гэдгийг ажил олгогчийн дээрх буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмжийг авч чадаагүй болох, эсхүл хугацаа нь ойшлогдох, тогтогдвол зохих тэтгэвэр бага хэмжээгээр тогтоогдох, зөрчигдсөн эрхээ эргээлгэхийн тулд тодорхой зардал гаргах зэргээр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах ирх нь зөрчигдсөнөөс даатгуулагчид учирсан эдийн хохирлыг ойлгоно.

Харин эрүүл мэндийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгогддоггүй, ажилгүйдлийн даатгалын сангаас зөвхөн нэг төрлийн тэтгэмж олгогддог тул эдгээр сангуудаас олгогддог

Мөн зүйл, хэсэгт заасан "ажил олгогч ирэн хариуцна" гэж ажил олгогчийн буруутай

тусламж, үйлчилгээ, тэтгэмжид энэ зүйлийн зохицуулалт хамаарахгүй.

Түүнчлэн, тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын сангуудаас олгогдох тахир дутуугийн хийгээд тэжээгчээ алдсаны тэтгэврүүд, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгогддог адил төрлийн тэтгэвэр, тэтгэмжээс шалтгаан ялгаатай нөхцөлтэй тул өөр төрлийн санд хамаарч байгаа хэдий ч тэдгээрийг давхардуулан олгохгүй.

Тэтгэмжийн даатгалын сангаас олгогддог оршуулгын тэтгэмж нь эдгээр сангуудаас олгогддог бусад тэтгэмжтэй цаг хугацааны хувьд давхцах боломжгүй тул давхардуулан олгогдох үндэслэлгүй болно.

Мөн зүйлд заасан **"даатгуулагч илүү таатай нөхцөлтэй тэтгэвэр буюу тэтгэмжийг ... сонгон авах эрхтэй"** гэдэгт даатгуулагч нэг төрлийн сангаас хэд хэдэн тэтгэвэр, эсхүл тэтгэмж авах үндэслэл үүсвэл хэмжээ, нөхцөл, эрх зүйн үр дагавар зэрэг нөхцлөөр өөрт ашигтай гэж үзсэн тэтгэвэр, тэтгэмжийн төрлийг сонгохыг хэлнэ.

Уг сонголтыг **"зөвхөн нэг удаа"** хийнэ гэдэг нь тухайн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, нөхцөл, эрх зүйн үр дагавар өөрчлөгдөөгүй байхад өөрийн хүсэлтээр урьд хийсэн сонголтоо даатгуулагч өөрчлөх эрхгүй байхыг хэлэх бөгөөд энэ нь тодорхой цаг хугацааны дараа даатгуулагчаас шалтгаалахгүй үндэслэлээр нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд сонголт хийх даатгуулагчийн эрхийг хязгаарлахгүй.

Түүнчлэн, даатгалын өөр төрлийн сангаас адил төрлийн тэтгэвэр, тэтгэмж авах үндэслэл зэрэг бүрдсэн нөхцөлд даатгуулагч сонголт хийхэд энэ зохицуулалт мөн үйлчилнэ.

**1.4.** Хуулийн 8 дугаар зүйлийн 2-т **"өргөдөл шийдвэрлэх хугацааг хуулиар тогтооно"** гэж зааснаар тухайн асуудлыг шийдвэрлэх хугацааг хуулиар тусгайлан тогтоогоогүй бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг баримтална.

**1.5.** Хуулийн 11 дүгээр зүйлийг дараахь байдлаар тайлбарласугай.

**1.5.1.** Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан **"нийгмийн даатгалын байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал"** гэдэгт зөвхөн нийгмийн даатгалын чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зардал хамаарах бөгөөд үүнийг эдгээр байгууллагын үйл ажиллагааны зардлаас бусад нийгмийн даатгалын сангийн хөрөнгөнөөс санхүүжүүлэхгүй гэж ойлгоно.

**1.5.2.** Мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан **"хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардал"** гэдэгт зөвхөн энэ хууль болон нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан бусад хуулиудад заасан төлбөр, зардлыг хамааруулна.

**1.5.3.** Энэ зүйлийн 2-т заасан **"хууль**

**тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно"** гэдгийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д зааснаар Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд гаргасан хуулийн зохицуулалтаар тухайн заалтыг өөрчлөхөөс өөр байдлаар нийгмийн даатгалын төрөл бүрд байрших мөнгөн хөрөнгийг сан хооронд шилжүүлэх, ашиглах, захиран зарцуулж болохгүй гэж ойлгоно.

**1.5.4.** Мөн зүйлийн 3-т заасан **"Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах"**-аас өөр хэлбэрээр буюу хуульд заагаагүй бусад байдлаар ашиглаж, байршуулж болохгүй.

**1.6.** Хуулийн 15 дугаар зүйлийн 5-д зааснаар ажил олгогч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг төлсөн явдал нь Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1-д заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөх, мөн түүний төлөх шимтгэлийн хэмжээ ялгавартай тогтоогдсон нь дээрх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл тус тус болохгүйг анхаарвал зохино.

**1.7.** Хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан **"...хөдөлмөрийн хөлс"** гэдэгт төрийн албан хаагчийн хувьд төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т зааснаар төрөөс олгож буй цалин хөлсийг ойлгоно.

Харин хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ажил олгогчоос олгож буй **"хөдөлмөрийн хөлс"** гэдэгт үндсэн цалин, ажлын үр дүнгээр олгосон нэмэгдэл хөлс, ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг биелүүлсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан тохиолдолд үндсэн цалингаас нь тооцож олгосон нэмэгдэл хөлснөөс гадна мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцлийн хийгээд бусад нэмэгдэл хамаарна.

**1.8.** Мөн зүйл, хэсэгт заасан **"...хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлого"** гэж цалин хөлснөөс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд тодорхойлсноор ажил олгогчоос олгож байгаа байнгын шинжтэй орлогыг хэлнэ.

**1.9.** Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогод ногдох шимтгэлийг төлөх үүргээ шимтгэл ногдох орлогоо нуух хэлбэрээр гүйцэтгээгүй, эсхүл бууруулах хэлбэрээр зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д **"орлоготой тэнцэх хэмжээний алданги**

ногдуулна” гэснийг Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.5-д заасан анхын агуулгаар нуусан буюу бууруулсан орлогод ногдох шимтгэлтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулна гэж ойлгоно.

1.10. Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийг дараах байдлаар тайлбарласгай.

1.10.1. Хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан **“тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг шимтгэлээ төлж дуустал түр зогсоох”** ажиллагаа нийгмийн даатгалын байгууллагын бүрэн эрхэд хамааралтай тул үл байгууллагын дарга, эсхүл эрх олгогдсон этгээдээс ирүүлсэн дансны зарлагын гүйлгээг зогсоох тухай мэдэгдлийг банк болон банк бус санхүүгийн байгууллага заавал биелүүлнэ.

1.10.2. Мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан **“зохих хууль тогтоомжийн дагуу гаргуулах”** гэж хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар үл маргах журмаар буюу шүүхийн бус журмаар төлбөр төлөгчийн харилцах данс, хөрөнгөөс төлбөрийг шууд гаргуулахыг хэлнэ.

1.11. Хуулийн 26<sup>1</sup> дүгээр зүйлийн 1-д заасан **“албан үүргээ гүйцэтгэх явцад”** гэснийг ажлын байрандаа болон ажил үүргээ бусад газарт гүйцэтгэх явцад, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд гэж ойлгоно.

1.12. Хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан **“даатгуулагчийг төлөөлж нийт ажилтны дийлэнх олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан үйлдвэрчний эвлэлийг төлөөлсөн 3 хүн”** гэдгийг үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь нийт ажилтны дийлэнх олонхийн ашиг сонирхлыг хамгаалдаг байгууллага тул үйлдвэрчний эвлэлийг төлөөлөх 3 гишүүн нь даатгуулагчийн төлөөлөөр Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлд орно гэж зйлговол зохино.

**Хоёр. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль**

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай /цаашид хууль гэх/ суулийн 3 дугаар зүйлийн 2-т заасан **“тэтгэврийн болон тэтгэмжийн шимтгэлийг ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө төлсөн нийт хугацаа”**-д БНМАУ-ын Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийг дагаж мөрдсөн 1991 оны 7 дугаар арын 1-ний өдрөөс хойш нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хамааруулна.

Мөн зүйл, хэсэгт заасан **“шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцооноор хуульд заасан үүсэд хугацаа”** гэдэгт энэ зүйлийн 3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх сурмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан угацааг тус тус хамааруулан ойлгоно.

2.2. Хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасан **“Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн этгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан эл тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ”** эдгийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны лмаас тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэн

тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан эсэхээс үл хамааран нэмэгдлийг авна гэж ойлгоно.

Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлж, мөн зүйлийн 2-т заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгон, хөдөлмөрийн хөлсийн 1.5 хувиар нэмэгдэл авч буй даатгуулагчид тахир дутуугийн тэтгэврийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

2.3. Хуулийн 6, 10, 15 дугаар зүйлд тус тус заасан **“нас барсны дараагийн сар дуустал олгоно”** гэдгийг нас барсан сарын тэтгэвэрээ тэтгэвэр авагч аваагүй байсан тохиолдолд тухайн сарын тэтгэврийг дараагийн сарын тэтгэврийн хамт, харин тэтгэвэрээ авсан бол дараа сарын тэтгэвэр л тус тус олгодоно гэж ойлгоно.

2.4. Хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т заасан **“даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээгдэхгүй болсныг”** Нийгмийн даатгалын тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлүүдэд заасны дагуу Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагаагаар тогтооно.

2.5. Хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан **“сургуульд суралцаж байгаа бол”** гэж боловсролын тухай хуульд заасан бага, дунд, дээд боловсрол олгох, боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг сургалтын байгууллагад өдрийн, оройн, эчнээ, экстернат хэлбэрээр албан болон албан бус сургалтад хамрагдаж байгааг хэлнэ.

2.6. Хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1-д заасан **“хүндэтгэх шалтгаан”** гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоолын 28-д заасантай адил ойлгож хэрэглэнэ.

2.7. Хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан **“ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагч”** гэдэгт Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6-д зааснаар ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасны дагуу иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа, Нийгмийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5-д зааснаас бусад төрлийн даатгалд даатгуулсан тэтгэвэр авагчийг хамааруулна. Мөн зүйлийн 4-т заасан **“тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас бодож өөрчлөн тогтооно”** гэснийг тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосноос хойш хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6-д зааснаар ажиллаж авсан цалингийн болон төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас тооцож өөрчлөн тогтооно гэж ойлгоно.

2.8. Хуулийн 29 дүгээр зүйлийн 2-т заасан **“нийгмийн даатгалын байгууллагын ажилтны алдаагаар буруу олгогдсон тэтгэвэр, тэтгэмж”** гэж



нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан үүрэгтэй хайнга хандсанаас шалтгаалан тэтгэвэр, тэтгэмж үндэслэлгүйгээр илүү тогтоогдсон, эсхүл тогтоогдсон хэмжээнээс илүү олгогдсон байхыг хэлнэ.

Тэтгэвэр, тэтгэмж үндэслэлгүйгээр илүү тогтоогдсон тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр тэтгэмж буруу тогтоосон шийдвэрийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасны дагуу хүчингүй болгож, тэтгэвэр авагчид илүү олгогдсон төлбөрийг буруутай албан тушаалтнаар төлүүлнэ.

Мөн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоогдсон хэмжээнээс илүү олгогдсон нийгмийн даатгалын байгууллагын ажилтан гэм буруутай нь тогтоогдвол түүнээс нөхөн гаргуулна.

Харин нийгмийн даатгалын байгууллагын ажилтны алдаагаар тэтгэвэр, тэтгэмж дутуу тогтоогдсон, эсхүл дутуу олгогдсон тохиолдолд энэ зүйлийн зохицуулалт хамаарахгүй ба тэтгэвэр авагчид учирсан хохирлын асуудлыг Иргэний хуулийн 52 дугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

## Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль

3.1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн /цаашид хууль гэх/ 2 дугаар зүйлийг дараахь байдлаар тайлбарласуяй.

3.1.1. Хуулийн 2 дугаар зүйлийн 1-д заасан "Даатгуулагч..." гэж энэ зүйл, хэсэг болон Нийгмийн даатгалын тухай хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д тодорхойлсон болзол, шаардлагыг хангасан, ажил хөдөлмөр эрхлээгүй хүнийг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан "...ажилгүйдлийн тэтгэмж..." гэдэгт ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг энэ хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн ажилгүй хүнд нийгмийн даатгалын сангаас амьжиргааны эх үүсвэр болгож, эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.

3.1.2. Ажилгүйдлийн тэтгэмжийг хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзол, шаардлагыг хангасан, хөдөлмөрийн насны, ажил хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэлтийн алба, уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн хүнд олгоно.

3.2. Хуулийн 5 дугаар зүйлд заасан "тооцоо хийж дууссанаас хойш 14 хоногийн дотор" гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар ажилтан ажлаа хүлээлгэн өгч, ажил олгогчоос хөдөлмөрийн гэрээ цуцалсан тухай шийдвэр, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хуульд заасан бол ажлаас халагдсаны

тэтгэмж авснаас хойш 14 хоногийн хугацаанд гэж ойлгоно.

Ажилтнаас хамаарахгүй шалтгаанаар ажил олгогчтой тооцоо хийх хугацаа хойшилсон явдал энэ зүйлд заасан хугацааг хэтрүүлсэн гэж үзэх үндэслэл болохгүй.

Мөн зүйлд "оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөр эрхлэлтийн алба, уг бирж байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй" гэж заасан тул ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдах эрх ажлаас халагдсан даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлснээр үүсэх бөгөөд энэхүү үүрэгтэй биелүүлээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдахыг шаардах эрхгүй.

3.3. Хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т зааснаар "хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон" нь даатгуулагчид олгож байгаа ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох үндэслэл болох бөгөөд энэ нь тэтгэвэр, тэтгэмж үргэлжлүүлэн авах ялтны эрхийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.1.8-д заасан зохицуулалтад хамааралгүй болно.

## Дөрөв.Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль

4.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн /цаашид хууль гэх/ 4 дүгээр зүйлийн 4.1-д "Иргэний эрүүл мэндийн даатгал нь төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу даатгалын шимтгэл төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын уг сангаас төлөх нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн" гэж заасны дагуу эрүүл мэндийн даатгал төлсөн даатгуулагчаас амбулаторид үзүүлэх, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх зэрэг үйлчилгээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т зааснаас бусад тохиолдолд төлбөр авах эрх зүйн үндэслэлгүй гэж үзнэ.

4.2. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан "тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй" болох нь татварын байгууллага болон оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргын тодорхойлолтоор тогтоогдсон байвал зохино.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 21, 2007 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 22, 2007 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 23 дугаар тогтоолуудыг хүчингүй болсон тооцсугай.

ТАНХИМЫН  
ТЭРГҮҮН  
ШҮҮГЧ

Д.БАТСАЙХАН  
Л.БЯМБАА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 262420  
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 1,5

☎ 329467